

- 8** 1 - 4 тоо бүхий ээрүүл эргүүдэхийн зэрэгцээ шоо орхих туршилт хийжээ. Энэ туршилтын үр дүнд дэс дараалсан хоёр үзэгдлээс тогтох нийлмэл үзэгдэл илрэнэ.
- а. Бүх боломжит эгэл үзэгдлийг хүснэгтээр харуулаарай. Эгэл үзэгдлүүдийн магадлал тэнцүү юу?
 - б. Ээрүүл тэгш тоогоор тогтох, шоо сондгой тоогоор тусах үзэгдэл хэдэн эгэл үзэгдлээс тогтох вэ? Уг үзэгдлийн магадлалыг ол.
 - в. Ээрүүл ба шооны тооны нийлбэр 8-тай тэнцэх үзэгдэл хэдэн эгэл үзэгдлээс тогтох вэ? Магадлалыг олоорой.
 - г. Магадлал нь $\frac{1}{12}$ -тэй тэнцүү ямар нэгэн үзэгдлийг ол.
- 9** Зоосон мөнгийг 3 удаа орхих туршилт хийв.
- а. Туршилтын дүнд нийт хэчинээн эгэл үзэгдэл илрэх вэ? Эгэл үзэгдлүүдийн магадлал тэнцүү байж чадах уу?
 - б. Бүх боломжит эгэл үзэгдлийн магадлалын нийлбэр 1-тэй тэнцүү болохыг шалгаж учрыг нь тайлбарлаарай.
 - в. Зоосон мөнгө аль талаараа тусах нь өмнөх орхилтын үр дүнгээс хамааралтай юу? Гурван удаа сүлд буух үзэгдлийн магадлал ямар байх вэ?
- 10** Цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.
- Дэс дараалсан үл хамаарах хоёр буюу хэд хэдэн үзэгдлээс тогтох үзэгдлийн магадлалыг олохын тулд тухайн үзэгдлүүдийн магадлалыг
- Хоёр буюу хэд хэдэн нийшгүй үзэгдлийн ядаж нэг нь илрэх магадлалыг олохын тулд тухайн үзэгдлүүдийн магадлалыг
- 11** Уутанд 10 улаан, 20 ногоон өнгийн чихэр байв. Уутанд гараа оруулан тэмтэрч чихэр гаргаж ирэхэд ногоон өнгөтэй байв. Дахин нэг чихэр гаргаж ирэхэд улаан өнгөтэй байх магадлалыг ол.
- 12** Батын цүнхэнд 4 улаан, 4 ногоон хараандаа байв. Тэрээр цүнхнээсээ таамгаар нэг хараандаа гаргаж ирэхэд тэр нь ногоон өнгийнх байв. Дахин нэг хараандаа гаргаж ирэхэд бас ногоон байх магадлалыг ол.